



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 30 өдөр

Дугаар А/16

Шивээговь сум

Үйл ажиллагааны хөтөлбөрийн
төлөвлөгөө батлах тухай


Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.8, 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, 74 дүгээр зүйлийн 74.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.5 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Шивээговь сумын Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Шивээговь сумын Засаг даргын 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг улирал бүрээр тайлагнахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Сугармаа), Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн (М.Гантуяа) нарт үүрэг болгосугай.

3.Төлөвлөгөөний хэрэгжилтийг нэгтгэж, хагас, бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэж, үр дүнг танилцуулан ажиллахыг Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн (М.Гантуяа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ